

## **Тарифын хөнгөлөлтийн ерөнхий системийг хэрэгжүүлэх тухай Европын Холбооны зөвлөлийн журам**

Европын Холбоо нь дэлхийн хөгжиж байгаа орнуудад хөнгөлөлт, өөрөөр хэлбэл импортын тарифын хөнгөлөлтийг дангаараа олгох систем (Хөнгөлөлтийн Ерөнхий систем)-ийг хэрэгжүүлж байна. Европын Холбоо худалдааны бодлогоо 10 жил тутам хянан шинэчилж, хэрэгжүүлэх тодорхой журам, хөнгөлөлтийн схемийг гурван жил тутам гаргадаг.

Европын Холбооноос гадна бусад бүх хөгжингүй орнууд ХЕС-ийг хэрэглэдэг ч Европын Холбооны ХЕС нь хамрах хүрээ болон хөнгөлөлтийн хэмжээгээр илүү бөгөөд тухайлбал 2003 онд хөгжиж байгаа орнуудаас 53 миллиард ам.долларын бүтээгдэхүүн Европын Холбооны зах зээлд тарифын хөнгөлөлттэй нэвтэрсэн байна.

Энэхүү ХЕС-ийн дагуу ихэнх хөгжиж байгаа орнуудад тарифын хөнгөлөлт олгохын зэрэгцээ тодорхой шалгуур хангасан зарим орнууд болон нэн буурай хөгжилтэй орнуудыг гаалийн татвараас бүрэн чөлөөлдөг.

Европын Холбоо 2006-2015 он хүртэл худалдааны хөнгөлөлтийн талаар баримтлах бодлогын чиглэлийг гаргаж, 2006-2008 онд мөрдөх худалдааны Хөнгөлөлтийн Ерөнхий Системийн (ХЕС) журмыг энэ оны 6-р дугаар сарын 27-ны өдрийн 980/2005 тоот тогтоолоор батлан гаргасан.

Манай улс хөгжиж байгаа орны хувьд 1991 оноос ХЕС-т хамрагдаж, импортын тарифын хөнгөлөлт эдэлж байсан ч манай экспортын ихэнх гол нэрийн бараа, бүтээгдэхүүн нь гаалийн татвараас бүрэн чөлөөлөгдөж байгаагүй юм.

Европын Холбоо жижиг, эмзэг эдийн засагтай, далайд гарцгүй хөгжиж байгаа орнуудын худалдаанд учирч байгаа бэрхшээлийг онцлон авч үзэж, хөгжлийн хэрэгцээ шаардлагыг дэмжих чиглэлээр худалдааны бодлого явуулдаг. Энэхүү үзэл баримтлалын хүрээнд ХЕС-ийн шинэ журмаар **"сайн засаглал, тогтвортой хөгжлийн"** болзлыг хангасан эмзэг эдийн засагтай орныг ХЕС-т хамруулж, 7200 гаруй нэр төрлийн бараа, бүтээгдэхүүнийг гаалийн татвараас чөлөөлөх шинэ хөнгөлөлтийг /GSP+/ бий болголоо.

Европын Холбоо нь энэхүү шинэ журмаар хөгжиж байгаа зарим орнуудад **"GSP+"** хөнгөлөлтийг олгохоор шийдвэрлэсний дотор манай улс багтаж байгаа нь манай улсын экспортыг нэмэгдүүлэх, экспортын үйлдвэрлэлийг дэмжихэд онцгой ач холбогдолтой үйл явдал болсон.

**ЗӨВЛӨЛИЙН ЖУРАМ (ЕХН) 980/2005**  
**2005 оны 6 дугаар сарын 27**

**Тарифын хөнгөлөлтийн ерөнхий системийг  
хэрэгжүүлэх тухай**

Европын холбооны зөвлөл, Европын Хамтын нийгэмлэгийг байгуулсан Гэрээ, ялангуяа Гэрээний 133-р зүйл, Комиссын санал, Европын Парламентын санал, Европын Эдийн засаг, нийгмийн хорооны саналыг тус тус харгалзан үзсэний үндсэн дээр,

- (1) Тус Хамтын нийгэмлэг нь 1971 оноос тарифын хөнгөлөлтийн ерөнхий системийн хүрээнд хөгжиж буй орнуудад худалдааны хөнгөлөлтийг олгож эхэлсэн.
- (2) Хамтын нийгэмлэгийн худалдааны нэгдсэн бодлого нь хөгжлийн бодлогын зорилтуудтай харилцан уялдах, ялангуяа хөгжиж буй орнуудад ядуурлыг бууруулах, тогтвортой хөгжил, сайн засаглалыг дэмжихэд чиглэнэ. Энэ нь ДХБ-ын шаардлагууд, нэн ялангуяа 1979 оны ТХЕХ-ийн Чадваржуулах нөхцөлтэй ( "Ялгавартай ба илүү таатай нөхцөл, харилцан таатай нөхцөл олгох, хөгжиж буй орнуудын бүрэн оролцоо", 1979 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн L/4903 тоот ТХЕХ-ийн журам) нийцэх ёстой.
- (3) Зөвлөл , Европын Парламент болон Европын эдийн засаг, нийгмийн хороонд Европын Комиссоос 2004 оны 7 дугаар сарын 7-нд хүргүүлсэн "Хөгжиж буй орнууд, олон улсын худалдаа ба тогтвортой хөгжил: 2006-2015 он буюу 10 жилийн хугацаанд хэрэгжих Хамтын нийгэмлэгийн хөнгөлөлтийн ерөнхий систем (ТЕХ)-ийн үүрэг, хэрэглээ" гэсэн мэдээлэл нь 2006 оноос 2015 он хүртэл тарифын ерөнхий хөнгөлөлтийг хэрэгжүүлэх удирдамжийг тодорхойлсон.
- (4) Энэхүү журам нь дээрхи удирдамжийг хэрэгжүүлэх анхны журам юм. Энэ нь 2008 оны 12 дугаар сарын 31 хүртэл хүчинтэй.
- (5) Тарифын хөнгөлөлтийн ерөнхий систем (цаашид систем гэх) нь хөнгөлөлтөнд хамрагдагч бүх орнууд болон нутаг дэвсгэрт хамаарах ерөнхий хөнгөлөлт ба ижил төстэй хөгжиж байгаа орнуудын янз бүрийн хөгжлийн хэрэгцээг харгалзан үзсэн хоёр тусгай хөнгөлөлтөөс тус тус бүрдэнэ.
- (6) Ерөнхий хөнгөлөлтийг Дэлхийн банкнаас гаргадаг өндөр орлоготой орнуудын ангилалд багтаагүй, түүнчлэн экспортын барааны төрөлжилт нь хангалттай бус орнуудад олгоно.
- (7) Тогтвортой хөгжил, сайн засаглалыг урамшуулах тусгай хөнгөлөлт нь 1986 оны НҮБ-ын Хөгжих эрхийн тухай тунхаглал, 1992 оны Риогийн Байгаль орчин, хөгжлийн тухай тунхаглал, 1998 оны

ОУХБ-ын Ажлын байрны үндсэн зарчим, эрхийн тухай тунхаглал, 2000 оны НҮБ-ын Мянганы Тунхаглал, 2002 оны Йоханнесбургийн Тогтвортой хөгжлийн тунхаглал зэрэг олон улсын конвенцууд болон арга хэрэгслээр хүлээн зөвшөөрөгдсөн тогтвортой хөгжлийн тухай ойлголтод тулгуурлана. Улмаар хүн ба хөдөлмөрийн эрх, байгаль хамгаалал, сайн засаглалын талаарх олон улсын үндсэн конвенцуудыг батламжлах, үр дүнтэй хэрэгжүүлэхтэй холбогдуулан хүлээх хүндхэн үүрэг, хариуцлагыг нь харгалзан үзвэл, олон улсын худалдааны тогтолцоонд хангалттай оролцдоггүй эмзэг эдийн засагтай орнуудад энэхүү тарифын нэмэлт хөнгөлөлт ихээхэн үр ашигтай юм. Эдгээр хөнгөлөлт нь эдийн засгийн цаашдын өсөлтийг дэмжихэд чиглэсэн бөгөөд чингэснээр тогтвортой хөгжлийн хэрэгцээ, шаардлагад эерэгээр тусна. Энэ зохицуулалтын хүрээнд үнийн дүнд ногдуулах татвар болон биет хэмжээнд ногдуулах татварыг (үнийн дүнд ногдуулах татвартай хослоогүй тохиолдолд) хөнгөлөлт эдлэгч улсуудын хувьд хүчингүй болгоно. Тогтвортой хөгжил, сайн засаглалын тусгай урамшууллын хөнгөлөлт нь хар тамхи үйлдвэрлэх, зөөвөрлөхтэй тэмцэх тусгай зохицуулалтын тухай ДХБ-ын шийдвэрийг даган мөрдөх зорилгоор энэхүү журмыг хүчин төгөлдөр болохоос өмнө хэрэгжинэ.

- (8) Энэхүү журмыг хүчин төгөлдөр болох үед тогтвортой хөгжил, сайн засаглалын тусгай хөнгөлөлтийн шалгуурыг хангасан хөгжиж буй орнууд нь энэ хөнгөлөлтөнд аль болох хурдан хамрагдах ёстой. Иймд тэдгээр орнуудыг хөнгөлөлт эдлэгч улсуудын жагсаалтад урьдчилсан байдлаар оруулна. Комисс тэдгээр орнуудын хүсэлтийг хүлээн авч, 2005 оны 12 дугаар сарын 15-аас өмнө нааштайгаар шийдвэрлэсэн тохиолдолд хөнгөлөлтийг үргэлжлүүлэн эдэлж болно.
- (9) Комисс нь холбогдох механизмын дагуу олон улсын конвенцуудын хэрэгжилтэд хяналт тавих бөгөөд тарифын нэмэлт хөнгөлөлт ба тогтвортой хөгжлийн хоорондын уялдаа, холбоонд үнэлэлт өгнө.
- (10) Нэн буурай хөгжилтэй орнуудад зориулсан тусгай хөнгөлөлтийг НҮБ-аас хүлээн зөвшөөрч, нэн буурай хөгжилтэй гэж ангилсан орнуудад бараа, бүтээгдэхүүнээ татваргүй оруулах эрхийг үргэлжлүүлэн олгоход зориулсан. НҮБ-ын нэн буурай хөгжилтэй орны ангиллаас хасагдсан орны хувьд энэхүү зохицуулалтын хүрээнд үзүүлж байсан тарифын хөнгөлөлт хүчингүй болсны улмаас үүсэж болох хүндрэлийг багасгах зорилгоор шилжилтийн хугацааг тогтооно.
- (11) Хамтын нийгэмлэгийн ижил төстэй бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй салбарын нөхцөл, байдлыг харгалзан үзэх зорилгоор бараа, бүтээгдэхүүнийг мэдрэмтгий байдлыг харгалзаж ялгаатай хөнгөлөлт олгох бодлогыг үргэлжлүүлнэ.

- (12) Мэдрэмтгий бус бараа, бүтээгдэхүүний тарифыг тэглэхийн сацуу мэдрэмтгий бараа, бүтээгдэхүүний тарифын ханамжит түвшинг хангахуйц бууруулах бөгөөд чингэхдээ Хамтын нийгэмлэгийн холбогдох үйлдвэрийн салбаруудын нөхцөл байдлыг харгалзан үзнэ.
- (13) Ийм тарифын бууралт нь хөнгөлөлтийн системийн олгож буй бололцоог ашиглах худалдаачдын сонирхлыг хангалттай өдөөхүйц байх ёстой. Гаалийн үнээс хувиар бодох татварын хувьд нэн тааламжтай үндэстний нөхцөлийн тарифыг 3,5 пунктээр бууруулна. Барааны нэгжид мөнгөн илэрхийллээр ногдуулах татварыг 30 хувиар бууруулна. Хамгийн доод түвшний татварын хувийг заасан тохиолдолд энэхүү татварыг ногдуулахгүй.
- (14) Энэхүү хөнгөлөлтийн дүнд импортын мэдэгдлийн үнээс хувиар бодох татвар нь 1 хувь буюу түүнээс бага байх эсвэл барааны нэгжид мөнгөн илэрхийллээр ногдуулах татвар 2 Евро буюу түүнээс бага байх тохиолдолд олох орлого нь татвар хураах зардлаас бага байх магадлалтай тул дээрх татварыг бүхэлд нь хүчингүй болгоно.
- (15) Хамтын нийгэмлэгийн худалдааны бодлогын уялдаа холбоог хангах үүднээс хөнгөлөлтөд хамрагдаж буй орны хувьд хэрэв чөлөөт худалдааны хэлэлцээр нь энэхүү хөнгөлөлтийн системийн хөнгөлөлтийг наад зах нь бүгдийг нь олгож буй тохиолдолд тухайн орон Хамтын нийгэмлэгийн хөнгөлөлтийн систем ба чөлөөт худалдааны хэлэлцээрт зэрэг хамрагдахгүй.
- (16) Тус хөнгөлөлтөөс хасахад Гаалийн нэгдмэл тарифын хэсгүүдтэй холбогдсон шалгуур, үзүүлэлт дээр үндэслэнэ. Хэрэв дараалсан гурван жилд шалгуурыг хангасан бол импортын статистикийн ихээхэн хэмжээний гажуудлын нөлөөг арилгах замаар хөнгөлөлтөөс хасах үйл ажиллагааг ойлгомжтой, шударга болгохын тулд хөнгөлөлт эдлэгч улсын барааны хэсгийг хөнгөлөлтөөс хасаж болно.
- (17) Хамтын нийгэмлэгийн Гаалийн кодыг батлах тухай Зөвлөлийн 291/92 тоот журмыг хэрэгжүүлэх асуудлыг тусгасан Комиссын 1993 оны 7 дугаар сарын 2-ны 2454/93 тоот журамд заасан бараа, бүтээгдэхүүний гарал үүслийн үзэл баримтлалын тодорхойлолтын дагуу гарал үүслийн дүрэм журам, холбогдох процедур болон хамтын ажиллагааны арга, хэлбэрийг энэхүү журмын дагуу хөнгөлөлт олгохдоо хэрэглэх бөгөөд ингэснээр зөвхөн хамрагдах ёстой орнуудад л хөнгөлөлтийн системийг олгоно.
- (18) Энэхүү журмын 3 дугаар Хавсралтад заасан конвенцуудын заалтыг удаа дараа болон ноцтойгоор зөрчих нь хөнгөлөлтөөс тодорхой хугацаагаар хасах үндэслэл болох бөгөөд энэ нь тэдгээр конвенцуудын зорилтыг дэмжих, хөнгөлөлт эдлэгч аливаа улс

тэдгээр конвенцуудыг үргэлжлүүлэн зөрчиж, шударга бусаар ашиг олохгүй байхыг баталгаажуулах зорилготой юм.

- (19) Мьянмар улс дахь улс төрийн байдлаас шалтгаалан Мьянмараас гарал үүсэлтэй импортын бараа, бүтээгдэхүүнийг тодорхой хугацаагаар хөнгөлөлтөд хамруулахгүй байх шийдвэр хүчинтэй хэвээр байна.
- (20) Комиссын хэрэгжүүлэх эрх мэдлийн процедурыг тодорхойлсон Зөвлөлийн 1999 оны 6 дугаар сарын 28-ны 1999/468/С тоот шийдвэрийн дагуу энэхүү журмыг хэрэгжүүлэхэд шаардагдах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

ЭНЭХҮҮ ЖУРМЫГ БАТЛАВ:

## **I БҮЛЭГ**

### **НИЙТЛЭГ ЗҮЙЛ**

#### *1 дүгээр зүйл*

1. Хамтын нийгэмлэгийн тарифын хөнгөлөтийн ерөнхий систем (цаашид систем гэх) нь энэхүү журам хүчин төгөлдөр болох өдрөөс эхлэн 2008 оны 12 дугаар сарын 31-нийг хүртэл энэ журмын дагуу үйлчилнэ.
2. Энэхүү журам нь дараах зүйлийг зохицуулна.  
Үүнд:
  - а. ерөнхий хөнгөлөлт,
  - б. тогтвортой хөгжил, сайн засаглалын тусгай урамшууллын хөнгөлөлт,
  - в. нэн буурай хөгжилтэй орнуудад зориулсан тусгай хөнгөлөлт.

#### *2 дугаар зүйл*

Энэхүү 1 дүгээр зүйлийн 2 дугаар заалтад дурдсан хөнгөлөлт эдлэгч улсуудыг 1 дүгээр Хавсралтад жагсаав.

### *3 дугаар зүйл*

1. Хөнгөлөлт эдлэгч улс нь Дэлхийн банкны өндөр орлоготой орны ангилалд 3 жил дараалан орсон, түүнчлэн тухайн орноос Хамтын нийгэмлэгт Хөнгөлөлтийн ерөнхий системийн хүрээнд нийлүүлж байгаа таван том бүлэг барааны импорт нь тус улсаас Хөнгөлөлттэй орж ирж байгаа нийт импортын 75 хувиас бага байвал энэхүү хөнгөлөлтөөс хасна.
2. Хөнгөлөлт эдлэгч улс нь Хамтын нийгэмлэгтэй худалдааны хөнгөлөлтийн хэлэлцээр байгуулсан бөгөөд энэхүү хэлэлцээр нь наад зах нь хөнгөлөлтийн ерөнхий системийн хүрээнд тухайн оронд олгож буй бүх хөнгөлөлтийг хамарч байгаа тохиолдолд тухайн орныг 1 дүгээр Хавсралтанд заасан Хөнгөлөлт эдлэгч улсуудын жагсаалтаас хасна.
3. Комисс аливаа орныг 1 дүгээр Хавсралтад заасан Хөнгөлөлт эдлэгч улсуудын жагсаалтаас хассан тохиолдолд энэ тухайгаа мэдэгдэнэ.

### *4 дүгээр зүйл*

1 дүгээр зүйлийн 2-т дурдсан хөнгөлөлтөнд хамрагдах бараа, бүтээгдэхүүнийг 2 дугаар Хавсралтад жагсаав.

### *5 дугаар зүйл*

1. Энэхүү журамд заасан тарифын хөнгөлөлт нь хөнгөлөлт эдлэгч улсаас гарал үүсэлтэй, хөнгөлөлтөд багтсан импортын бараа, бүтээгдэхүүнд үйлчилнэ.
2. 1 дүгээр зүйлийн 2 дугаар заалтад заасан хөнгөлөлтийг зохицуулахад мөрдөх бараа, бүтээгдэхүүний гарал үүслийн үзэл баримтлалын тодорхойлолтын дагуух гарал үүслийн дүрэм журам, холбогдох процедур болон тэдгээртэй холбоотой хамтын ажиллагааны арга, хэлбэрийг Комиссын 2454/93 тоот журамд заасан.
3. Бүс нутгийн бүлэгт хамрагддаг аль нэг орны эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд хэрэглэгдэх бүтээгдэхүүн нь уг бүс нутгийн бүлэгт хамрагддаг боловч тухайн эцсийн бүтээгдэхүүнд хөнгөлөлт авдаггүй өөр нэг орноос гаралтай бол Комиссын 2454/93 тоот журамд заасан бүс нутгийн хуримтлалын ойлголтын хүрээнд эдгээр орнууд бүс нутгийн хуримтлалд хамрагдана.

## 6 дугаар зүйл

Энэхүү журмын зорилгоор:

а. "Гаалийн нэгдмэл тарифын татвар" гэдэгт тариф ба статистикийн нэр, төрлийн тухай Зөвлөлийн 1987 оны 7 дугаар сарын 23-ны 2658/87 тоот журмын 1 дүгээр Хавсралтын 2 дугаар хэсэгт заасан, тарифын квотын хүрээнд тогтоосон татвараас бусад татварыг ойлгоно.

б. "Хэсэг" гэдэг нь 2658/87 тоот журмаар батлагдсан Гаалийн нэгдмэл тарифын аль ч хэсэг байж болно. Энэхүү журмаар 11 дүгээр хэсгийг хоёр тусдаа хэсэг гэж үзнэ. Энэ нь Гаалийн нэгдмэл тарифын 50-60 дугаар бүлгийг хамарсан 11(а) хэсэг ба 61-63 дугаар бүлгийн хамарсан 11 (б) хэсэг болно.

в. "Хороо" гэж 28 дугаар зүйлд заасан Хороог хэлнэ.

## II БҮЛЭГ

### ЗОХИЦУУЛАЛТ БА ТАРИФИЙН ХӨНГӨЛӨЛТ

#### 1 ДҮГЭР ХЭСЭГ

##### *Ерөнхий зохицуулалт*

## 7 дугаар зүйл

1. 2 дугаар Хавсралтад заасан, хөдөө аж ахуйн бараа, бүтээгдэхүүнээс бусад мэдрэмтгий бус бараа, бүтээгдэхүүнийг Гаалийн нэгдмэл тарифын татвараас бүрэн чөлөөлнө.
2. 2 дугаар Хавсралтад заасан мэдрэмжтэй бараа, бүтээгдэхүүний үнийн дүнд ногдуулах Гаалийн нэгдмэл тарифын татварыг 3,5 пунктээр бууруулна. 11(а), 11 (б) хэсгийн бараа, бүтээгдэхүүний татварыг 20 хувиар бууруулна.
3. 2 дугаар Хавсралтад заасан мэдрэмжтэй бараа, бүтээгдэхүүний үнийн дүнд ноогдуулах Гаалийн нэгдмэл тарифын татварыг 3,5 пунктээр бууруулна. 11(а), 11 (б) хэсгийн бараа, бүтээгдэхүүний татварыг 20 хувиар бууруулна. Гаалийн нэгдмэл тарифын тухай (ЕХН) 2501/2001 журмын 7 дугаар зүйлийн дагуу тооцсон, энэхүү журмыг хүчин төгөлдөр болохоос өмнө хэрэглэж байсан гаалийн үнийн дүнд ногдуулах хөнгөлөлттэй татварын хувь хэмжээ нь энэхүү зүйлийн 2 дугаар заалтад заасан бараа, бүтээгдэхүүний хувьд 3,5 пунктээс илүү буурахаар байвал тэдгээр гаалийн хөнгөлөлттэй татварын хувийг хэрэглэнэ.

4. 2 дугаар Хавсралтад заасан мэдрэмтгий бараа, бүтээгдэхүүний доод ба дээд түвшний татвараас бусад барааны нэгжид ногдуулах Гаалийн нэгдмэл тарифын татварыг 30 хувиар бууруулна.
5. 2 дугаар Хавсралтад заасан мэдрэмтгий бараа, бүтээгдэхүүний Гаалийн нэгдмэл тарифын татварт үнийн дүн болон барааны нэгжид ногдуулах татвар хосолсон тохиолдолд барааны нэгжид ногдуулах татварын хэмжээг бууруулахгүй.
6. Энэ зүйлийн 2 болон 4 дүгээр заалтын дагуу бууруулах татвар нь дээд түвшний татвар байх тохиолдолд татварыг бууруулахгүй. Харин доод түвшний татвар байвал доод түвшний татвар нь хүчингүй болно.
7. 14 дүгээр зүйл, 21 дүгээр зүйлийн 8 дугаар заалт, 1 дүгээр Хавсралтын В баганад заасны дагуу тухайн орны хувьд эдгээр тарифын хөнгөлөлтийг хүчингүй болгосон бараа, бүтээгдэхүүн нь 1-4 дүгээр заалтад заасан тарифын хөнгөлөлтөд хамаарахгүй.

## **2 ДУГААР ХЭСЭГ**

### ***Тогтвортой хөгжил, сайн засаглалын тусгай Урамшууллын зохицуулалт***

#### *8 дугаар зүйл*

1. Тогтвортой хөгжил, сайн засаглалын тусгай урамшууллын зохицуулалтад хамрагдсан орны хувьд 2 дугаар Хавсралтад заасан бүх бараа, бүтээгдэхүүнийг үнийн дүнд ноогдуулах Гаалийн нэгдмэл тарифын татвараас чөлөөлнө.
2. Үнийн дүнд болон биет хэмжээнд ногдуулах татвар хосолсон Гаалийн нэгдмэл тариф бүхий бараа, бүтээгдэхүүнээс бусад 1 дүгээр заалтад дурдсан бараа, бүтээгдэхүүнээс бусад 1 дүгээр заалтад дурдсан бараа, бүтээгдэхүүнийг Гаалийн нэгдмэл тарифын биет хэмжээнд ногдуулах татвараас бүрэн чөлөөлнө. 17041091, 17041099 гэсэн НЖ-ын кодтой бараа, бүтээгдэхүүний хувьд биет хэмжээнд ногдуулах татвар нь гаалийн үнэлгээний 16 хувиас хэтрэхгүй байна.
3. Тогтвортой хөгжил, сайн засаглалын тусгай урамшууллын зохицуулалтад хамрагдсан орны хувьд 1 дүгээр Хавсралтад В хэсэгт заасан тарифын хөнгөлөлтийг эдлэхгүй бараа, бүтээгдэхүүнд хамаарахгүй.



## 9 дүгээр зүйл

1. Тогтвортой хөгжил, сайн засаглалын тусгай урамшууллын зохицуулалтад дараах орнууд хамрагдана. Үүнд:

- (а) 3 дугаар Хавсралтын А хэсэгт заасан конвенцуудад нэгдэн орж, үр дүнтэй хэрэгжүүлж байгаа,
- (б) 3 дугаар Хавсралтын Б хэсэгт заасан конвенцуудаас хамгийн багаар бодоход 7 конвенцид нэгдэн орж, үр дүнтэй хэрэгжүүлж байгаа,
- (в) 3 дугаар Хавсралтын Б хэсэгт заасан хараахан нэгдэн орж амжаагүй конвенцуудыг 2008 оны 12 дугаар сарын 31-нээс өмнө батламжилж, үр дүнтэй хэрэгжүүлэх чин эрмэлзэлтэй байгаа,
- (г) Конвенцуудыг батламжилж, тэдгээрийг хэрэгжүүлэх чиглэлээр хууль, журам гарган арга хэмжээ авч байгаа, батламжилсан конвенцуудын хэрэгжүүлэх заалтын кагуу хэрэгжилтийн явцын талаарх хяналт, шалгалтыг хүлээн зөвшөөрсөн,
- (д) Энэ зүйлийн 3 дугаар заалтад тодорхойлсны дагуу эмзэг орон байх зэрэг болно.

2. Үндсэн хуулиас шалтгаалж 1 дүгээр заалтын (а), (б) хэсгийг хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй тулгарч байгаа орнуудын хувьд шаардлагыг хөнгөвчлөхийн тулд 3 дугаар Хавсралтын А хэсэгт заасан 16 конвенцуудаас 2-оос ихгүй конвенцийг батламжлаагүй, үр дүнтэй хэрэгжүүлээгүй орныг тогтвортой хөгжил, сайн засаглалын тусгай урамшууллын зохицуулалтад хамруулж болох бөгөөд чингэхдээ:

- (а) Тухайн орон өөрийн Үндсэн хуультай зөрчилдөхгүй гэдгийг тогтоон, 2005 оны 10 дугаар сарын 31-нээс өмнө дутуу байсан конвенцуудад нэгдэн орж, хэрэгжүүлэхээ албан ёсоор мэдэгдсэн, мөн
- (б) Тухайн орон Үндсэн хуультай нь зөрчилдөж байгаа тохиолдолд дутуу байгаа конвенцуудад 2006 оны 12 дугаар 31-нээс өмнө нэгдэн орж, хэрэгжүүлэхээ албан ёсоор мэдэгдсэн байх ёстой.

Комисс нь холбогдох орнууд дээрх заалтуудыг хэрхэн хэрэгжүүлж буй талаар 2006 оны эцсээр Зөвлөлд тайлагнана. Тэдгээр орнуудыг 2007 оны 1 дүгээр сарын 1-ээс хойш тогтвортой хөгжил, сайн засаглалын тусгай урамшууллын зохицуулалтад хамруулах эсэхийг Зөвлөл шийдвэрлэнэ. Зохистой тохиолдолд буюу дээр дурдсан тайланд үндэслэн Комисс энэ талаарх саналаа Зөвлөлд илэрхийлнэ.

3. Эмзэг орон гэдэг нь:

- (а) дараалсан 3 жилийн үзүүлэлтээр Дэлхийн Банкны өндөр орлоготой орны ангилалд ороогүй, мөн Хамтын нийгэмлэгийн зах зээлд

Хөнгөлөлтийн ерөнхий системийн (ХЕС) хөнгөлөлттэй тарифаар нийлүүлж байгаа таван том бүлэг барааны импорт нь тус улсаас ХЕС-ийн хөнгөлөлттэй орж ирж байгаа нийт импортын 75%-иас илүүгүй байх, мөн

- (б) Хамтын нийгэмлэгийн зах зээлд ХЕС-ийн хөнгөлөлттэй тарифаар нийлүүлж байгаа барааны импорт нь Хамтын нийгэмлэгийн ХЕС-ийн хөнгөлөлттэй орж ирж байгаа нийт импортын 1%-иас доогуур байх ёстой.

Энэ тухайд ашиглах мэдээлэл нь 2004 оны 9 дүгээр сарын 1-ны мэдээлэл байх бөгөөд дараалсан 3 жилийн дунджаар тооцно.

4. Комисс 3 дугаар Хавсралтад заасан конвенцуудад нэгдэн орох, үр дүнтэй хэрэгжүүлэх асуудалд хяналт тавина. Энэхүү журам хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө буюу дараагийн журмыг хэлэлцэх үед Комисс эдэгээр конвенцуудад нэгдэн орсон байдлын талаар болон хяналтын байгууллагуудын зөвлөлмжийг Зөвлөлд танилцуулна.

#### *10 дугаар зүйл*

1. Тогтвортой хөгжил, сайн засаглалын тусгай урамшууллын зохицуулалтад дараах нөхцөлийг хангасан тохиолдолд 3-р заалтын үйлчлэлийг бууруулахгүйгээр хамруулна. Үүнд:
- (а) 1 дүгээр Хавсралтад жагсаасан улс буюу нутаг дэвсгэр нь 2005 оны 10 дугаар сарын 31-нээс өмнө хүсэлтээ гаргасан бол, мөн
- (б) 1 дүгээр Хавсралтад жагсаасан улс буюу нутаг дэвсгэр нь 2005 оны 10 дугаар сарын 31-нээс өмнө хүсэлтээ гаргасан бол, мөн
- (в) Хүсэлт гаргагч улсын хүсэлтийг хянах явцад тухайн орон 9 дүгээр зүйлийн 1,2,3 дугаар заалтын нөхцөлийг хангаж байгаа нь нотлогдвол хамруулна.
2. Хүсэлт гаргагч улс нь Комисст хүсэлтээ бичгээр гаргах бөгөөд 3 дугаар Хавсралтад заасан конвенцуудад нэгдэн орсон тухай, тэдгээрийн заалт болон хүлээсэн үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэх талаар авч буй арга хэмжээ, хууль, журмын тухай дэлгэрэнгүй мэдээллээр хангана. Түүнчлэн конвенцуудын хяналт, үнэлгээний талаарх заалтуудыг бүрэн хэрэгжүүлэхээ илэрхийлсэн байна.
3. Энэхүү журмыг хүчинтэй болсон өдрөөс эхлэн тогтвортой хөгжил, сайн засаглалын тусгай урамшууллын хөнгөлөлтөд урьдчилсан байдлаар хамрагдсан орнууд 1 ба 2 дугаар заалтын дагуу 2005 оны 10 дугаар сарын 31-нээс өмнө хүсэлтээ гаргана. Комисс хүсэлтийг 11 дүгээр зүйлд заасанчлан авч үзнэ.

### *11 дүгээр зүйл*

1. Комисс 10 дугаар зүйлд заасан мэдээлэл бүхий хүсэлтийг хүлээн авч судална. Судалгааг хийхдээ холбогдох олон улсын байгууллагуудын мэдээллийг харгалзан үзнэ. Шаардлагатай гэж үзсэн аливаа асуудлыг хүсэлт гаргагч улсаас тодруулж болох ба ирүүлсэн мэдээллийг хянан баталгаажуулж болно.
2. Комисс нь 1 дүгээр заалтад тусгасан судалгаа болон 28 дугаар зүйлийн 4-т заасан процедурын дагуу хүсэлт гаргагч улсыг 2006 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн тогтвортой хөгжил, сайн засаглалын тусгай урамшууллын хөнгөлөлтөд хамруулах эсэхийг шийдвэрлэнэ.
3. Комисс 2 дугаар заалтын дагуу гаргасан шийдвэрийг хүсэлт гаргагч улсад мэдэгдэнэ. Түүнчлэн урамшууллын тусгай хөнгөлөлтөд хамрагдах болсон тохиолдолд энэхүү шийдвэрийн хүчинтэй болох огноог мэдэгдэнэ. Комисс 2005 оны 12 дугаар сарын 15-ны дотор Европын холбооны Албан ёсны сэтгүүлд тогтвортой хөгжил, сайн засаглалын тусгай урамшууллын хөнгөлөлтөд хамрагдах орнуудын жагсаалтыг нийтлэнэ.
4. Хүсэлт гаргагч улс нь тусгай хөнгөлөлтөд хамрагдаагүй тохиолдолд уг улсын хүсэлтээр Комисс тайлбар гаргаж өгнө.
5. Комисс нь хүсэлт гаргагч улстай уг асуудлаар харилцахдаа 28 дугаар зүйлийн 4 дүгээрт заасны дагуу Хороотой нягт хамтран ажиллана.

### **3 ДУГААР ХЭСЭГ**

#### ***Нэн буурай хөгжилтэй орнуудад зориулсан тусгай зохицуулалт***

### *12 дугаар зүйл*

1. 1 дүгээр Хавсралтад заасан нэн буурай хөгжилтэй орнуудад зориулсан тусгай зохицуулалтын дагуу хөнгөлөлтөд хамрагдаж буй улсын хувьд Уялдуулсан системийн 1-97 (93-р бүлгийн зарим бараанаас бусад) бүлгүүдэд заасан бүх бараа, бүтээгдэхүүнийг Гаалийн нэгдмэл тарифын татвараас 2, 3, 4 дүгээр заалтын үйлчлэлийг бууруулахгүйгээх бүрэн чөлөөлнө.
2. 1006 тарифын бүлгийн бараа, бүтээгдэхүүний Гаалийн нэгдмэл тарифын татварыг 2006 оны 9 дугаар сарын 1 гэхэд 20 хувиар, 2007 оны 9 дүгээр сарын 1 гэхэд 50 хувиар, 2008 оны 9 дүгээр 1 гэхэд 80 хувиар тус тус бууруулна. 2009 оны 9 дүгээр сарын 1-нд бүрэн чөлөөлнө.

3. Нэгдсэн жагсаалтын 0803 00 19 кодтой бараа, бүтээгдэхүүний Гаалийн нэгдмэл тарифын татварыг 2002 оны 1 дүгээр сарын 1-нээс хойш жил бүр 20 хувиар бууруулна. 2006 оны 1 дүгээр сарын 1-ний дотор бүрэн чөлөөлнө.
4. 1701 тарифын бүлгийн бараа, бүтээгдэхүүний Гаалийн нэгдмэл тарифын татварыг 2006 оны 7 дугаар сарын 1 гэхэд 20 хувиар, 2007 оны 7 дугаар сарын 1 гэхэд 50 хувиар, 2008 оны 7 дугаар сарын 1 гэхэд 80 хувиар тус тус бууруулна. 2009 оны 7 дугаар сарын 1-ний дотор бүрэн чөлөөлнө.
5. Гаалийн нэгдмэл тарифын татвар 2, 4 дүгээр заалтын дагуу бүрэн чөлөөлөгдөх хүртэл энэхүү тусгай зохицуулалтад хамрагдах орнуудаас гаралтай 1006 тарифын бүлэг, 1701 11 10 дэд бүлгийн бараа, бүтээгдэхүүнд жил бүр тэг татвартай тарифын квот тогтооно. 2001/2002 оны тарифын квот нь 1006 тарифын бүлгийн бараа, бүтээгдэхүүний хувьд цагаан будааны 2,517 тоннтой, 1701 11 10 дэд бүлгийн бараа, бүтээгдэхүүний хувьд элсэн чихрийн 74,185 тоннтой тэнцүү байсан. Дараагийн жилүүдэд жил бүрийн квот нь өмнөх квотын жилийн квотын хэмжээнээс 15 хувиар нэмэгдэнэ.
6. 28 дугаар зүйлийн 4 дүгээрт заасан процедурын дагуу 5 дугаар заалтад заасан квотын зохицуулалтыг хэрэгжүүлэх нарийвчилсан дүрэм, журмыг Комисс батална. Эдгээр квотыг тогтоох, хэрэгжүүлэх Комиссын үйл ажиллагаанд нэгдсэн зах зээлийн холбогдох байгууллагын удирдлагын хороод дэмжлэг үзүүлнэ.
7. Хэрэв аливаа улс нь НҮБ-ын нэн буурай хөгжилтэй орны жагсаалтаас хасагдсан тохиолдолд энэхүү тусгай хөнгөлөлтийг эдлэгч улсуудын жагсаалтаас мөн хасагдана. Комисс 28 дугаар зүйлийн 4 дүгээр заалтад заасан процедурын дагуу тухайн улсыг тусгай зохицуулалтаас хасах болон доод тал нь 3 жилийн шилжилтийн хугацаа тотоох талаар шийдвэр гаргана.

### *13 дугаар зүйл*

1701 11 10 тарифын дэд бүлгийн бараа, бүтээгдэхүүнтэй холбоотой 12 дугаар зүйлийн 4, 5 дугаар заалт нь энэхүү хэсэгт хамааралтай, гадаад дахь Францын хэлтсүүдэд үнэгүй тараасан хөнгөлөлт эдлэгч улсуудаас гаралтай бараа, бүтээгдэхүүнд хамаарахгүй.

## **4 ДҮГЭЭР ХЭСЭГ**

### ***Нийтлэг зүйл***

#### 14 дүгээр зүйл

1. Хамтын нийгэмлэгийн тухайн барааны хэсэгт хөнгөлөлт авдаг орноос импортолсон уг барааны дундаж үнийн дүн нь хамгийн сүүлийн үеийн мэдээллээр буюу 2004 оны 9 дүгээр сарын 1-ний байдлаар 3 жил дараалан 1 дүгээр Хавсралтад заасан бүх орон, нутаг дэвсгэрээс Хамтын нийгэмлэгийн импортолсон уг барааны үнийн дүнгийн 15 хувиас илүү хувийг эзэлж байвал 7 ба 8 дугаар зүйлд заасан тарифын хөнгөлөлт нь хүчингүй болно. 9 (а), 9 (б) хэсгүүдийн хувьд уг босго нь 12,5 хувь байна.
2. 1 дүгээр заалтын дагуу хүчингүй болгосон барааны хэсгийг 1 дүгээр Хавсралтын В баганад жагсаав.
3. Энэхүү хөнгөлөлтийн системээс хассан хэсгийг 2006 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2008 оны 12 дугаар сарын 31 хүртэл хэрэгжүүлнэ.
4. Комисс аливаа хэсгийг хөнгөлөлтөөс хассан тухайгаа хөнгөлөлт эдлэгч улсад мэдэгдэнэ.
5. Хөнгөлөлт эдлэгч улсаас Хамтын нийгэмлэгийн импортолсон бараа, бүтээгдэхүүний хэсэг нь Хамтын нийгэмлэгийн тухайн орноос гаралтай, Хөнгөлөлтийн ерөнхий системд хамрагдсан нийт импортын үнийн дүн 50-иас илүү байвал уг орны хувьд 1 дүгээр заалт үйлчлэхгүй.
6. Энэхүү зүйлд хэрэглэх статистикийн мэдээний эх сурвалж нь COMEXT статистик байна.

#### 15 дугаар зүйл

1. Энэхүү Бүлэгт заасны дагуу хөнгөлж буй тухайн нэг импортын мэдүүлгийн үнийн дүнд ногдуулах татварын хувь хэмжээ нь 1 хувь буюу түүнээс бага байвал гаалийн татварыг бүхэлд нь тэглэнэ.
2. Энэхүү Бүлэгт заасны дагуу хөнгөлж буй тухайн нэг импортын мэдүүлгийн биет хэмжээнд ногдуулах татвар 2 Евро буюу түүнээс бага байвал гаалийн татварыг бүхэлд нь тэглэнэ.
3. Энэхүү журмын дагуу 1, 2 дугаар заалтад заасан хөнгөлөлттэй татварын эцсийн хувь хэмжээг тооцоолохдоо эхний аравтын бутархай орон хүртэл бүхэлдэнэ.

### III БҮЛЭГ

#### ТҮР ЦУЦЛАЛТ БА ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ ЗААЛТ

# 1 ДҮГЭЭР ХЭСЭГ

## Түр цуцлалт

### 16 дугаар зүйл

1. Хөнгөлөлт эдлэгч улсаас гаралтай бүх буюу зарим бүтээгдэхүүний хувьд энэхүү журамд заасан хөнгөлөлтийн зохицуулалтыг дараах аль нэг шалтгаанаар түр цуцалж болно. Үүнд:
  - (а) 3 дугаар Хавсралтын А хэсэгт жагсаасан конвенцуудад заасан зарчмыг ноцтойгоор болон удаа дараа зөрчсөн тохиолдолд зохих хяналтын байгууллагын дүгнэлтийн үндсэн дээр,
  - (б) шоронд хоригдогсдын хөдөлмөрөөр бүтсэн бараа, бүтээгдэхүүний экспорт,
  - (в) хууль бус мансууруулах бодисын экспорт, дамжин тээвэрлэлтэд тавих гаалийн хяналтад ноцтой зөрчил, дутагдал илэрсэн буюу мөнгө угаах гэмт хэргийн тухай олон улсын конвенцийг дагаж мөрдөөгүй,
  - (г) Хамтын нийгэмлэгийн аж үйлдвэрт сөрөг нөлөөтэй, хөнгөлөлт эдлэгч улс анхаарч шийдвэрлээгүй худалдааны шударга бус практикийн ноцтой хэлбэр буюу удаа дараагийн үйлдэл; ДХБ-ын хэлэцээрүүдээр хориглосон буюу арга хэмжээ авах худалдааны шударга бус практикийн тухай энэхүү зүйлийг хэрэгэлэхдээ ДХБ-ын эрх бүхий байгууллагын өмнөх шийдвэрийг үндэслэл болгох,
  - (д) Хамтын нийгэмлэгийн нэгдэн орсон загасны нөөцийг хадгалах, зохицуулах тухай бүс нутгийн загасны аж ахуйн байгууллага буюу гэрээ, хэлэцээрийн зорилтыг ноцтойгоор буюу удаа дараа зөрчих зэрэг болно.
2. Ялангуяа тухайн улсын хууль, журам нь 9 дүгээр зүйлийн 1, 2 дугаар заалтад буй шаардлагыг биелүүлэхийн тулд баталсан 3 дугаар Хавсралтад заасан конвенцуудад нийцэхээ больсон буюу эсвэл тухайн хууль, журмыг үр дүнтэй хэрэгжүүлэхгүй байгаа тохиолдолд 1 дүгээр заалтын үйлчлэлийг бууруулахгүйгээр II бүлгийн 2 дугаар хэсэгт заасан тусгай урамшууллын зохицуулалтад хамруулах, хөнгөлөлт эдлэгч улсаас гаралтай бүх буюу зарим бүтээгдэхүүний хувьд энэхүү зохицуулалтыг түр хүчингүй болгож болно.
3. 384/96 (Хамтын нийгэмлэгийн гишүүн бус орнуудын импортын эсрэг хамгаалалтын арга хэмжээ авах тухай 1995 оны 12-р сарын 22-ны өдрийн Зөвлөлийн журам) буюу 2026/97 (Хамтын нийгэмлэгийн гишүүн бус орнуудын татаастай импортын эсрэг хамгаалалтын арга хэмжээ авах 1997 оны 10-р сарын 6-ны өдрийн Зөвлөлийн журам) тоот журмын (ЕХН) дагуу дампингийн эсрэг буюу саармагжуулах арга хэмжээ авах бүтээгдэхүүний хувьд эдгээр арга хэмжээг үндэслэл

болгох шалтгаанаар 1(г) заалтын дагуу энэхүү журамд заасан хөнгөлөлтийн зохицуулалтыг хүчингүй болгохгүй.

### 17 дугаар зүйл

1. Залилан мэхлэх, хэвийн бус үйлдэл гаргах, бараа, бүтээгдэхүүний гарал үүслийн талаарх дүрэм, журам, түүнтэй холбоотой горим, журмыг дагаж мөрдөхгүй, хэрэгжилтийг хангахгүй, 1 дүгээр зүйлийн 2-т заасан зохицуулалтын хэрэгжилт, түүний хяналтад шаардлагатай захиргааны хамтын ажиллагааг үзүүлэхгүй байх явдлыг удаа дараа гаргасан тохиолдолд хөнгөлөлт эдлэгч улсаас гаралтай бүх буюу зарим бүтээгдэхүүний хувьд энэхүү журамд заасан хөнгөлөлтийн зохицуулалтыг хүчингүй болгож болно.
2. 1 дүгээр заалтад заасан захиргааны хамтын ажиллагааны хүрээнд хөнгөлөлт эдлэгч улс нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:
  - (а) гарал үүслийн талаарх дүрэм, журмыг хэрэгжүүлэх, түүний хэрэгжилтийг хянахад шаардлагатай мэдээллийг Комисст өгч, уг мэдээллийг шинэчилж байх,
  - (б) Гишүүн орнуудын гаалийн байгууллагын хүсэлтээр гарал үүслийн баталгаажуулалтыг хийхэд нь Хамтын нийгэмлэгт туслах, үр дүнг цагт нь мэдэгдэх,
  - (в) 1 дүгээр зүйлийн 2-т заасан зохицуулалтын хөнгөлөлтийг олгохтой холбоотой баримт бичгийн жинхэнэ эсэх, мэдээллийн үнэн зөв эсэхийг шалгахын тулд Гишүүн орнуудын эрх бүхий байгууллагуудтай хамтран тухайн улсад Хамтын нийгэмлэгийн захиргааны болон шалгах хамтын ажиллагааны багийг томилон ажиллуулахыг Комисст зөвшөөрөх замаар Комисст туслах,
  - (г) гарал үүслийн талаарх дүрэм журмын зөрчлийг олж тогтоох, урьдчилан сэргийлэх зохих шалгалтыг явуулах буюу ийм шалгалтад бэлтгэх,
  - (д) хэрэв тухайн улс 2454/93 тоот журмын (ЕХН) үр ашгийг хүртдэг бол тус журмын хүрээнд бүс нутгийн хуримтлалын хувьд гарал үүслийн талаарх дүрэм журмыг биелүүлэх буюу биелэлтийг хангах,
  - (е) гарал үүсэлтэй холбоотой залилан мэхлэх үйлдэл гарсан гэж үзсэн тохиолдолд Комисст шалгалт явуулахад туслах. Энэ журмын дагуу олгож, хөнгөлөлттэй горимоор импортолсон бараа, бүтээгдэхүүн нь хөнгөлөлт эдлэгч орны экспортын ердийн түвшнээс асар их хэмжээгээр илүү гарсан тохиолдолд залилан мэхлэх үйлдэл гарсан гэж үзэж болно.

3. Комисс нь 1, 2 дугаар заалтад заасан шалтгааныг түр цуцлалтын үндэс болгоно гэдгийг нотлох хангалттай баримт байна гэж үзвэл хөнгөлөлт эдлэгч улсаас гаралтай бүх буюу зарим бүтээгдэхүүний хувьд энэ журамд заасан хөнгөлөлтийн зохицуулалтыг түр хүчингүй болгож болно. Гэхдээ эхлээд дараах ажиллагааг хийнэ. Үүнд:

- Хороонд мэдэгдэх,

- Хамтын нийгэмлэгийн санхүүгийн эрх ашгийг хамгаалах буюу хөнгөлөлт эдлэгч орны үүргээ биелүүлэх явдлыг хангахын тулд шаардлагатай ийм урьдчилан сэргийлэх арга хэмжээг авахыг Гишүүн орнуудад уриалах,

-Хөнгөлөлтийн зохицуулалтыг хэрэглэх эсэх буюу хөнгөлөлт эдлэгч улс үүргээ биелүүлж байгаа эсэх талаар эргэлзээ төрүүлэх, улмаар энэхүү журмаар олгосон хөнгөлөлтийг эдлэх эрхэд нь эргэлзээ төрүүлэх үндэслэл байгаа тухай мэдэгдлийг “Европын Холбооны албан ёсны сэтгүүлд”-д нийтлэх зэрэг болно.

Комисс нь энэхүү заалтын дагуу гаргасан аливаа шийдвэрийг хүчин төгөлдөр болохоос өмнө үүний талаар хөнгөлөлт эдлэгч талд мэдэгдэх ёстой. Комисс нь мөн энэ талаар Хороонд мэдэгдэнэ.

4. Аливаа Гишүүн улс 3 дугаар заалтын дагуу гаргасан шийдвэрийг 1 сарын дотор Зөвлөлд мэдэгдэнэ. Зөвлөл 1 сарын дотор олонхын саналаар өөр шийдвэр гаргаж болно.
5. Түр хүчингүй болгох хугацаа 6 сараас хэтэрч болохгүй. Энэ хугацаа дуусахад 3 дугаар заалтад заасан журмын дагуу Комисс нь Хороонд мэдэгдэж түр хүчингүй болгосон хугацааг дуусгавар болгох буюу сунгана.
6. Гишүүн орнууд хөнгөлөлтийг түр хүчингүй болгох буюу түр хүчингүй болгосон хугацааг сунгах үндэслэл болохуйц холбогдолтой бүх мэдээллийг Комисст мэдэгдэнэ.

#### 18 дугаар зүйл

1. Комисс буюу Гишүүн улс нь түр хүчингүй болгох үндэслэл болж болох мэдээллийг хүлээж авах ба Комисс болон Гишүүн улс нь шалгах хангалттай үндэслэл байна гэж үзвэл Хороонд мэдэгдэж зөвлөлдөх хүсэлт тавих бөгөөд зөвлөлдөөн 1 сарын дотор болно.
2. Зөвлөлдсөний дараа Комисс нь 1 сарын дотор 28 дугаар зүйлийн 5-т заасан журмын дагуу шалгалтыг эхлүүлэх шийдвэрийг гаргаж болно.

#### 19 дүгээр зүйл

1. Комисс нь шалгалтыг эхлүүлэхээр шийдсэн тохиолдолд уг шалгалтын талаарх мэдэгдлийг “Европын Холбооны албан ёсны сэтгүүлд”-д



- нийтлэн зарлахын сацуу тухайн хөнгөлөлт эдлэгч улсад энэ талаар мэдэгдэх ёстой. Уг мэдэгдэлд хүлээн авсан мэдээллийн товч агуулгыг тусгаж, аливаа холбогдох мэдээллийг Комисст илгээхийг мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд сонирхсон талууд санал, бодлоо бичгээр гаргаж болох хугацааг заана. Энэ хугацаа нь мэдэгдэл хэвлэгдсэн өдрөөс хойш дөрвөн сараас хэтэрч болохгүй.
2. Комисс нь тухайн хөнгөлөлт эдлэгч улсад шалгалтын явцад хамтран ажиллах бүх боломжийг олгоно.
  3. Комисс нь шаардлагатай гэж үзсэн бүх мэдээлэл, үүний дотор НҮБ, ОУХБ-ын зохих хяналт, шалгалтын байгууллага болон олон улсын бусад эрх бүхий байгууллагаас үнэлгээ, санал, шийдвэр, зөвлөмж, дүгнэлтийг хүсэж болно. Эдгээр нь түр цуцлах шийдвэрийн 16-р зүйлийн 1(а)-д заасан шалтгаан дээр үндэслэж байгаа эсэх тал дээр шалгалт хийж эхлэх үндэслэл болно. Комисс нь хүлээн авсан мэдээллийг эдийн засгийн үйл ажиллагаанд оролцогчид болон тухайн хөнгөлөлт эдлэгч улстай тулган шалгаж болно.
  4. Комиссыг нутаг дэвсгэр дээр нь шалгалт явуулахыг Гишүүн улс хүсвэл тус улсын албан тушаалтнууд нь Комисст тусалж болно.
  5. Шалгалтыг зарласан мэдэгдлийн заасан хугацааны дотор Комиссын хүссэн мэдээллийг өгөхгүй буюу шалгалтад мэдэгдхүйц саад учруулсан тохиолдолд байгаа баримт дээр үндэслэн дүгнэж болно.
  6. Шалгалтыг 1 жилийн дотор хийж гүйцэтгэх ёстой. 28 дугаар зүйлийн 5-т заасан журмын дагуу Комисс нь энэ хугацааг сунгаж болно.

#### 20 дугаар зүйл

1. Комисс нь Хороонд дүгнэлтийнхээ талаар тайлан гаргаж өгнө.
2. Комисс нь түр цуцлах шийдвэрийг гаргах үндэслэлгүй гэж үзвэл 28 дугаар зүйлийн 5-т заасан журмын дагуу шалгалтыг дуусгах шийдвэр гаргаж болно. Энэ тохиолдолд Комисс нь шалгалт дууссан тухай болон шалгалтын дүгнэлтийг *"Европын Холбооны албан ёсны сэтгүүлд"*-д нийтлэх ёстой.
3. Комисс нь 16 дугаар зүйлийн 1(а)-д заасан шалтгаанаар түр цуцлах шийдвэрийг гаргах үндэслэл байна гэж дүгнэвэл 28 дугаар зүйлийн 5-т заасан журмын дагуу тухайн хөнгөлөлт эдлэгч улсын нөхцөл байдлыг 6 сарын турш хянаж, үнэлэх шийдвэрийг гаргаж болно. Комисс нь энэхүү шийдвэрийн талаар тухайн хөнгөлөлт эдлэгч улсад мэдэгдэж, хугацаа дуусахаас өмнө тухайн хөнгөлөлт эдлэгч улс нь 3 дугаар Хавсралтын А хэсэгт заасан конвенцуудыг зохих хугацааны дотор биелүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авахаар амлалт, үүрэг авахгүй бол түр хүчингүй болгох саналыг Зөвлөлд оруулах гэж

байгааг мэдэгдэж "Европын Холбооны албан ёсны сэтгүүлд"-д нийтлэх ёстой.

4. Комисс нь түр хүчингүй болгох шаардлагатай гэж үзсэн зохих саналыг Зөвлөлд оруулна. Зөвлөл нь үүнийг хүчинтэй олонхын саналаар 1 сарын дотор шийднэ. 3 дугаар заалтын үйлчлэлийн үед Комисс нь тус заалтад заасан хугацааны эцэст саналаа оруулна.
5. Зөвлөл нь түр цуцлах шийдвэр гаргасан тохиолдолд шийдвэр гаргах үндэслэл нь хэвээр байвал анх гаргасан өдрөөс хойш 6 сарын дараа хүчин төгөлдөр болгоно.

## **2 ДУГААР ХЭСЭГ**

### ***Хамгаалалтын арга хэмжээний тухай зүйл***

#### *21 дүгээр зүйл*

1. Хөнгөлөлт эдлэгч улсаас гаралтай бараа, бүтээгдэхүүнийг Хамтын нийгэмлэгийн гишүүн улсын ижил төстэй буюу шууд өрсөлдөх бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд ноцтой бэрхшээл учруулах эсвэл учруулахаар заналхийлэх нөхцөлөөр импортолж байвал Гишүүн улсын хүсэлтээр буюу комиссын санаачилгаар ямар ч үед тухайн бүтээгдэхүүний хувьд Гаалийн нэгдсэн тарифын татварыг дахин мөрдөж болно.
2. Комисс нь зохих хугацааны дотор шалгалтыг эхлүүлэх албан ёсны шийдвэрийг гаргана. Комисс нь шалгалтыг эхлүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд шалгалтыг зарласан мэдэгдлийг "Европын Холбооны албан ёсны сэтгүүлд"-д нийтлэх ёстой. Уг мэдэгдэлд хүлээн авсан мэдээллийн товч агуулгыг тусгаж, аливаа холбогдох мэдээллийг Комисст илгээх хэрэгтэй гэж мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд сонирхсон талууд санал, бодлоо бичгээр гаргаж болох хугацааг заана. Энэ хугацаа нь мэдэгдэлд хэвлэгдсэн өдрөөс хойш 4 сараас хэтэрч болохгүй.
3. Комисс нь Комисс нь шаардлагатай гэж үзсэн бүх мэдээллийг хүсэх бөгөөд хүлээн авсан мэдээллийг тухайн хөнгөлөлт эдлэгч улс болон бусад аливаа холбогдох эх сурвалжтай тулган шалгаж болно. Комиссыг нутаг дэвсгэр дээрээ шалгалт явуулахыг Гишүүн улс нь хүсвэл тус улсын албан тушаалтнууд Комисст тусалж болно.
4. Ноцтой бэрхшээл байгаа эсэхийг шалгахдаа Комисс нь мэдээлэл байгаа тохиолдолд Хамтын нийгэмлэгийн үйлдвэрлэгчдэд хамаатай дараах хүчин зүйлсийг тооцож үзнэ. Үүнд:

-зах зээлд эзлэх хувь,

-үйлдвэрлэл,

- хувьцаа,
- үйлдвэрийн хүчин чадал,
- дампуурал,
- ашигтай байдал,
- хүчин чадлын ашиглалт,
- ажил эрхлэлт,
- импорт,
- үнэ.

5. 2 дугаар заалтад заасан мэдэгдлийг нийтлэгдсэнээс хойш 6 сарын дотор шалгалтыг хийж дуусгах ёстой бөгөөд онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд Комисс нь Хороотой зөвлөлдсөний үндсэн дээр 28 дугаар зүйлийн 5-т заасан журмын дагуу энэхүү хугацааг сунгах шийдвэрийг гаргаж болно.
6. Комисс нь 28 дугаар зүйлийн 5-т заасан журмын дагуу 1 сарын дотор шийдвэр гаргах ёстой. Энэхүү шийдвэр нь нийтлэгдсэн өдрөөсөө хойш 1 сарын дотор хүчин төгөлдөр байна.
7. Даруй арга хэмжээ авах шаардлагатай онцгой нөхцөл байдлаас үүдэн шалгалт явуулах боломжгүй болбол Комисс нь хороонд мэдэгдсэний үндсэн дээр онц шаардлагатай урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч болно.
8. Хөнгөлөлт эдлэгч улсаас гаралтай, 11(б) хэсгийн бараа, бүтээгдэхүүний импорт нь 14 дүгээр зүйлийн 1-т заасны дагуу:
  - (а) хуанлины урьд жилтэй харьцуулахад тоо хэмжээний хувьд 20-иос дээш хувиар өссөн,
  - (б) 12 сарын туршид 1 дүгээр Хавсралтад жагсаасан бүх улс, нутаг дэвсгэрээс Хамтын нийгэмлэгт импортолсон 11(б) хэсгийн бараа, бүтээгдэхүүний үнийн дүнгийн 12,5%-иас хэтэрсэн тохиолдолд, Комисс нь энэхүү журмыг хэрэгжих хугацааны турш жил бүрийн 1 дүгээр сарын 1-нд өөрийн санаачилгаар буюу Гишүүн улсын хүсэлтээр Хороонд мэдэгдсэний үндсэн дээр 9(б) хэсгийн бараа, бүтээгдэхүүний хувьд 7, 8 дугаар зүйлд заасан хөнгөлөлтийг хүчингүй болгоно. 12 дугаар зүйлд заасан нэн буурай хөгжилтэй орнуудад зориулсан тусгай зохицуулалтад хамрагдсан орнууд болон 14 дүгээр зүйлийн 1-т тодорхойлсны дагуу Хамтын нийгэмлэгт оруулах импортын эзлэх хувь хэмжээ нь 8%-иас хэтрэхгүй улс орнуудад энэхүү заалт нь хамаарахгүй. Комисс нь хөнгөлөлтийг хүчингүй болгосон тухай хөнгөлөлт эдлэгч улсад мэдэгдэнэ. Хөнгөлөлт хүчингүй болгосон шийдвэр нь "Европын Холбооны албан ёсны сэтгүүлд"-д нийтлэгдсэнээс хойш 2 сарын дараа хүчин төгөлдөр болно.

1. Гэрээний 1 Хавсралтад заасан бараа, бүтээгдэхүүний импорт нь Хамтын нийгэмлэгийн зах зээл, ялангуяа хамгийн доод зах нь нэг буюу түүнээс олон бүс нутаг буюу тэдгээр зах зээлийн зохицуулах механизмд ноцтой уршиг тарих буюу тарих аюул учруулж байвал Комисс нь өөрийн санаачилгаар буюу Гишүүн улсын хүсэлтээр тухайн нэгдсэн зах зээлийн байгууллагын удирдах хороотой зөвшилцсөний үндсэн дээр тухайн бүтээгдэхүүний хувьд хөнгөлөлтийн зохицуулалтыг түр хүчингүй болгож болно.

### *23 дугаар зүйл*

1. Комисс нь 21, 22 дугаар зүйлийн дагуу гаргасан шийдвэрийг хүчин төгөлдөр болохоос өмнө тухайн хөнгөлөлт эдлэгч улсад аль болох даруй мэдэгдэх ёстой. Комисс нь мөн энэ талаар Зөвлөл болон гишүүн улсуудад мэдэгдэх ёстой.
2. Аливаа гишүүн улс 21, 22 дугаар зүйлийн дагуу гаргасан шийдвэрийн талаар 1 сарын дотор Зөвлөлд хандаж болно. Зөвлөл 1 сарын дотор хүчинтэй олонхын саналаар өөр шийдвэрийг гаргаж болно.

## **3 ДУГААР ХЭСЭГ**

### ***Хөдөө аж ахуйн салбар дахь тандалтын арга хэмжээ***

### *23 дугаар зүйл*

